



I/2022

Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 14




Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 2207 (2.2 дахин)-гоор өссөн байна

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны 1 дүгээр сард 3996 болж, өмнөх оны мөн үеэс 2207 (2.2 дахин)-гоор, харин өмнөх сараас 1247 (45.4%)-гоор өссөн байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1436 (2.7 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 536 (2.0 дахин), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 90 (2.7 дахин)-ээр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 236 хэргийн 18 (7.6%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2022 оны 1 дүгээр сард 918 зөрчил бүртгэгдсэний 464 (50.5%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 267 (41.0%)-гоор, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 128 (38.1%)-аар тус тус өсжээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны 1 дүгээр сард 19 болж, өмнөх оны мөн үеэс 11 (2.4 дахин)-ээр өссөн байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2022 оны 1 дүгээр сард 236 болж, өмнөх оны мөн үеэс 116 (96.7%)-гаар, эмэгтэй хүн оролцсон хэрэг 320 болж, 160 (2.0 дахин)-аар, хүүхэд оролцсон хэрэг 33 болж, 20 (2.5 дахин)-оор, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 542 болж, 308 (2.3 дахин)-аар, бүлэглэн үйлдсэн хэрэг 159 болж, 86 (2.2%)-гаар, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 15 болж, 3 (25.0%)-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 2. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2022 оны 1 дүгээр сард 108.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 39.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 100.5 (14.0 дахин) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 38.3 (42.0 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, насны бүлгээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2022 оны 1 дүгээр сард 1435 болж, өмнөх оны мөн үеэс 763 (2.1 дахин)-аар өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 45 (3.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 170 (11.8%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН, ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2021 I	2022 I	2021 I	2022 I	2021 I	2022 I
	7 хүртэлх	15	12	3	6	10
8-17	59	208	16	54	1	4
18-29	392	974	153	364	17	16
30-39	511	1 170	184	354	26	46
40-49	336	806	96	210	17	37
50-59	194	458	55	102	25	38
60-69	63	125	13	33	8	8
70, түүнээс дээш	11	42	2	12	4	5
Улсын дүн	1 581	3 795	522	1 135	108	158
Эмэгтэй	691	1 647	220	419	24	45

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2022 оны 1 дүгээр сард 3.8 мянга болж, 220 (5.8%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 1647 (43.4%) нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас 2022 оны 1 дүгээр сард 1135 хүн гэмтэж, 158 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 613 (2.2%)-аар, нас барсан хүн 50 (46.3%)-аар өсжээ.


Улсын хэмжээнд 2022 оны 1 дүгээр сард 5.9 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 837 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 637 (12.0%)-гоор, баривчлагдсан хүн 137 (19.6%)-гоор өссөн байна.

Авлигатай тэмцэх газарт 2022 оны 1 дүгээр сард авлигын 39 хэрэг бүртгэгджээ

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны 1 дүгээр сард авлигын 39 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 (95.0%)-өөр өсжээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 13 (76.5%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 39 авлигын хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 30 (73.2%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 6 (14.6%) нь хахууль авах гэмт хэрэг, 1 (2.4%) нь хахууль өгөх гэмт хэрэг, 2 (5.0%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 1 (2.4%) нь дураараа аашлах гэмт хэрэг, 1 (2.4%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг байна.

ЗУРАГ 4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ, хэргийн төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг; Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Авлигын гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.



Эх үүсвэр:

Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлэл

Ангилал, код:

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 03 дугаар сарын 14

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын
статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212